



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/45

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.10, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал батлах тухай” А/156 дугаар тушаалын 3 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 1 дүгээр багийн нутаг “Хавтгай уул” нэртэй талбайд хууль бусаар жонш олборлосны улмаас эвдрэлд орсон газарт экологи эдийн засгийн үнэлгээ хийж, нөхөн сэргээлтэд шаардлагатай зардлыг тооцох ажлыг хийж гүйцэтгэсэн Байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага “Ойт бүс” ХХК-ийн гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилтэд 2,066,350 (хоёр сая жаран зургаан мянга гурван зуун тавин) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даал асугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010134